



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/327

Булган сум

Аймгийн Засаг даргын орон тооны бус  
зөвлөхүүдийн ажил үүргийн хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх ажлын чиг үүргийн хүрээнд аймгийн Засаг даргын орон тооны бус зөвлөхүүдийн ажиллах ажлын чиг үүргийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Өөрсдийн чиг үүргийн хүрээнд аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн шинэлэг ажлуудыг санаачлан, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг орон тооны бус зөвлөхүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР





Аймгийн Засаг даргын орон тооны бус зөвлөхүүдийн  
ажлын чиг үүргийн хуваарь

**1.Хуулийн бодлогын зөвлөх:**

- ✓ Засаг даргад хууль зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлж хамтран ажиллах
- ✓ Хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулах, хянахад зөвлөгөө өгөх
- ✓ Аймгийн Засаг дарга бусад хүмүүсийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан ажиллаж зохих эрх бүхий байгууллагад төлөөлөх
- ✓ Аливаа зөвшилцөл, гэрээ хэлэлцээр, гадаад дотоодын хамтын ажиллагаанд шаардлагатай үйл ажиллагаа явуулахад эрх зүйн зөвлөгөө өгөх

**2.Гадаадад харилцааны асуудал хариуцсан зөвлөх:**

- ✓ Гадаад оронтой эдийн засгийн үр өгөөжтэй харилцааг санаачлан хэрэгжүүлэх
- ✓ Гадаад хамтын ажиллагааны хүрээнд оюутан залуучуудыг суралцуулах, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, сургах, гэрээт ажилтан бэлтгэх, гадаад улсын өндөр технологийг нэвтрүүлэх
- ✓ Гадаад улсаас тус аймгийн салбар бүрд хөрөнгө оруулалтыг татах
- ✓ Булган аймгийн сум бүрийг гадаад улс орнуудтай нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуйн чиглэлээр хамтран ажиллах асуудлыг судалж, хэрэгжүүлэх

**3.Бизнес хөрөнгө оруулалт хариуцсан зөвлөх:**

- ✓ Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнс, хөдөө аж ахуйн чиглэлд хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийг татах санал санаачилгыг гаргах
- ✓ Хөрөнгө оруулалтын чиглэлийн уулзалт, зөвлөгөөн зохион байгуулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх, хамтран ажиллах
- ✓ Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг оновчтой тодорхойлж, төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд зөвлөн туслах
- ✓ Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн, үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих төсөл хөтөлбөр татах

**4.Эдийн засаг, төлөвлөлт хариуцсан зөвлөх:**

- ✓ Орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэх, бүсийн албан татварын бодлого, орон нутгийн төсвийн зөв төлөвлөлт хийхэд арга зүйн зөвлөмж өгөх
- ✓ Орон нутгийн өмчит компанийн үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарах
- ✓ Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүжилтийн олон эх үүсвэрээс дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд хамтран ажиллах

**5.Эрүүл мэндийн асуудал хариуцсан зөвлөх:**

- ✓ Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусгагдсан эрүүл мэндийн чиглэлийн гол зорилтуудыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн тусламж зөвлөгөө үзүүлэн ажиллах

- ✓ Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон хавдрын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэхэд чиглэсэн “Эрүүл Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах
- ✓ Эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, гадаад, дотоодод сургах, туршлага судлуулах замаар эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэн, залгамж халааг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх
- ✓ Хүн амд хүрч буй анхан шатны тусламж үйлчилгээний асуудалд анхаарч хөрөнгө оруулалтыг татах

#### **6.Соёлын асуудал хариуцсан зөвлөх:**

- ✓ Соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалж, өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд арга зүйн зөвлөгөө өгч ажиллах
- ✓ Бүх нийтийн соёлын боловсролыг хөгжүүлэх арга хэмжээг дэмжиж ажиллах
- ✓ Соёлын чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийг дэмжих чиглэлээр гадаад дотоодын туршлагыг нэвтрүүлэх
- ✓ Соёл урлагийн мэргэжилтэй боловсон хүчний тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн их дээд сургуультай хамтарсан төслийг хэрэгжүүлэх
- ✓ Соёлын өвийг хамгаалах, шинээр хамгаалалтад авах ажлыг сайжруулах
- ✓ Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан соёлын чиглэлийн ажлыг хэрэгжүүлэхэд олон улсын төсөл хөтөлбөрийг татах

#### **7.Аялал, жуулчлал хариуцсан зөвлөх:**

- ✓ Бүс, нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах, хөрөнгө оруулалтыг татах
- ✓ Орон нутгийн онцлогт түшиглэсэн, төрөлжсөн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд төсөл хөтөлбөр хэрэгжүүлж хамтарч ажиллах
- ✓ Аялал жуулчлалын бүсэд орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох нөхцөл бололцоог судалж төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх

#### **8.Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан зөвлөх:**

- ✓ Хөдөө аж ахуйн болон мал аж ахуйн салбарын тогтвортой үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж, гадаад дотоодын туршлагыг нутагшуулахад хамтран ажиллах
- ✓ Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө-Сэргэлт” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтыг татах
- ✓ “Шинэ-хоршоо” хөдөлгөөнийг эрчимжүүлэх ажилд арга зүйн дэмжлэг үзүүлэх

#### **9.Бүсчилсэн хөгжил, залуучуудын асуудал хариуцсан зөвлөх:**

- ✓ Бүс нутгийн тэргүүлэх чиглэл, байгаль газар зүйн нөхцөл, нөөц, байршлын давуу талтай уялдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- ✓ Бүсийн хөгжлийн бодлогод нийцсэн татварын бодлого хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- ✓ Аймаг, сумын зарим холбогдох баримт бичгийг бүсүүдийн эдийн засагт гүйцэтгэх чиг үүрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулах ажлыг хийж гүйцэтгэх
- ✓ Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан өсвөр үе, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон, сонирхолтой өнгөрүүлэх, идэвх,

оролцоог дэмжих “Залуусын хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах

- ✓ Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн /эрэгтэй, эмэгтэй/ эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах арга зүйн дэмжлэг үзүүлэх
- ✓ Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлэхэд гадаад дотоодын төсөл арга хэмжээг татах ажлыг хийх